

**Жимс жимсгэнэ боловсруулах, хадгалах техник,
ТЕХНОЛОГИ**



2020 он

Жимс, жимсгэний ач холбогдол

- Бид өдөр тутамдаа шим тэжээлийн алдагдалгүй, эрүүл органик бүтээгдэхүүн хэрэглэх нь чухал юм. Хүний бие махбодын хэвийн үйл ажиллагааг зохицуулах, хүч чадлыг нэмэгдүүлэх, эрүүл чийрэг өсөж хөгжихөд жимс, жимсгэнэ нэн чухал. Хүн хоногт 300г-гаас доошгүй, жилд 109-112 кг жимс, жимсгэнэ, түүний бүтээгдэхүүнээр хийсэн хүнс тэжээл, ундааны зүйл хэрэглэх шаардлагатай гэж эрдэмтэд үздэг байна.
- Жимс, жимсгэнэ бол чихэрлэг ихтэй, олон янзын органик хүчил, бичил язгуур махбод, төрөл бүрийн витамин агуулсан байдаг учир хүнс тэжээлээс гадна эмийн үйлдвэрийн үнэт түүхий эд болно.
- Жимс жимсгэнийг шинээр нь боловсруулан хатаасан жимс болон жимсний шүүс хийх төхөөрөмжийг та бүхэнд танилцуулж байна.

Жимс жимсгэнэ хатаагч

Жимс хатаагч машин нь тухайн жимсэнд агуулагдах амин дэм, эрдэс бодисын агуулагыг алдагдуулалгүй хатааж, урт хугацаанд хадгалах боломж олгодог онцлогтой.

Машины хэмжээ	300мм x 360мм x 350мм
Торон тавиурын хэмжээ	285мм x 200мм
Тавиурын нүхны диаметр	7мм
Торон тавиурын тоо	6 давхар
Материал	Үл зэврэх сайн чанарын ган
Цахилгаан зарцуулалт	400W
Цахилгаан хэрэглээ	220V - 240V
Цагийн тохируулга	1-24 цаг
Температур	30°C-80°C
Ажиллах үеийн дуу чимээ	45 db
Үйлдвэрийн үнэ	1160 юань



Жимс, жимсгэний хатаамал хийх

- Жимсээ сайтар угааж, бэлтгээд өөрийн хүссэн хэлбэр дүрсээрээ 1-2см зузаантай хэрчинэ.
- Бэлтгэсэн жимсээ төхөөрөмжиндөө өрж хийнэ. Жимс хатаагчаа тогонд залгаж 5-10 минут ажиллуулахад таны жимсний хатаамал бэлэн болно. Жимсээ хэр зузаан хэрчсэнээс хамааран хэдэн минут хатаахаа шийднэ.



Жимсний шүүс шахагч

Жимс жимсгэнэ, хүнсний ногооны шүүсийг шахахын өмнө угааж цэвэрлэсэн байх бөгөөд жижиглэн хэрчсэн байх хэрэгтэй. Жижиг хэрчих тусам шүүсний алдагдал бага байх болно.

Загвар	WF-A3000 Жижиг машин	WF-A2000 Том машин
Цахилгаан хэрэглээ	220 вольт	220 вольт
Цахилгаан зарцуулалт	370 ватт/цаг	500 ватт/цаг
Хөдөлгүүрийн эргэх хурд	2800 эрг/мин	2800 эрг/мин
Цэвэр жин	12кг	19кг
Бохир жин	13кг	20кг
Хүчин чадал	80-100 кг/цаг	100-120 кг/цаг
Хэмжээ:	340мм х 270мм х 360мм	430мм х 350мм х 450мм
Хайрцагийн хэмжээ:	360мм х 285мм х 420мм	435мм х 355мм х 520мм
Материал	SUS304 сайн чанарын ган	SUS304 сайн чанарын ган
Үйлдвэрийн үнэ	1480 юань	1980 юань



Жимсний шүүс хийх


Сонгосон жимсээ сайтар угааж цэвэрлээд жижиглэж бэлтгэнэ. Машиныг ажлын бэлэн байдалд байгааг шалгаад цахилгааны эх үүсвэрт залгана. Хамгийн багадаа 10 амперийн гүйдлийн хүч бүхий цахилгаан сүлжээнд ажиллана.

Анхаар:

- Тагны хоёр талын түгжээг байнга цоожилсон байна.
- Хатуулаг ихтэй жимсний шүүсийг шахах боломжгүй. Тухайлбал: тоор, манго, хатсан банан, наргил модны самар ГЭХ МЭТ.
- Машиныг цахилгаан тэжээлээс бүрэн салгасны дараа хаягдлыг гаргаж авна.
- Машинд цэвэрлэгээ хийхдээ хүнсний зориулалтын угаалгын нунтаг хэрэглэж байх хэрэгтэй. Бүх эд ангийг цэвэрлэсэний дараа ургамлын тосоор арчина.

ASTAN





Манай вэб сайтаар зочилсонд
баярлалаа.

Та хөдөө аж ахуйн чиглэлээр сургалт, зөвлөгөө, мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй хамтарч ажиллаарай.